

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ,ГОМДОЛ НЭГ
ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН Г.ЭРДЭНЭСУГАРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2021 он**

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна.

2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 2920 өргөдөл ирсэн. Үүнээс хуулийн хугацаанд 2819, хугацаа хэтрүүлэн 48 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2020 оны тайлант хугацаанд 08 хоног 22 цаг 08 минут байсныг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 08 хоног 01 цаг 14 минут болгон бууруулсан үзүүлэлттэй байна.

Үүнээс Засаг даргын Тамгын газарт 878 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 854 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 19 өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 07 хоног, 16 цаг, 05 минут байна.

| Хан-Уул дүүрэг | Нийт өргөдөл | | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн | | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | | Шийдвэрлэлтийн дундаж хоног | | Зөрчлийн тоон үзүүлэлт | |
|-----------------------------------|--------------|-------------|--------------------------------|-------------|-----------------------------|-------------|-----------------------------|-------------|------------------------|-------------|
| | 2020/12 сар | 2021/12 сар | 2020/12 сар | 2021/12 сар | 2020/12 сар | 2021/12 сар | 2020/12 сар | 2021/12 сар | 2020/12 сар | 2021/12 сар |
| ИТХ | 58 | 23 | 58 | 23 | 0 | 0 | 04x07 ц 29м | 09x01 ц20м | 77 | 18 |
| ЗДТГ | 586 | 892 | 570 | 854 | 6 | 19 | 07x09 ц 45м | 07x16 ц05м | 289 | 822 |
| Харьяа хэлтэс, алба, тасаг | 2045 | 1639 | 1974 | 1584 | 40 | 18 | 10x06 ц 37м | 08x12 ц47м | 946 | 572 |
| Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд | 47 | 6 | 45 | 5 | 1 | 1 | 06x19 ц 23м | 11x10 ц53м | 52 | 22 |
| Хороод | 270 | 108 | 262 | 99 | 8 | 1 | 04x05 ц 08м | 02x18 ц56м | 204 | 62 |
| Эмнэлэг | 162 | 203 | 154 | 196 | 5 | 3 | 09x21 ц 44м | 08x13 ц06м | 257 | 235 |
| Сургууль, цэцэрлэг | 65 | 49 | 64 | 44 | 1 | 6 | 20x22 ц 57м | 15x03 ц39м | 0 | 36 |
| Дүүргийн хэмжээнд /нийт/ | 3233 | 2920 | 3127 | 2819 | 61 | 48 | 08x22 ц 08м | 08x01 ц14м | 1844 | 1767 |

ХОЁР. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 хоног бүр Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулан, шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөх, өргөдөл гомдлыг удирдлагын түвшинд шуурхай шилжүүлж байх талаар мэдээлэл өгч ажиллаж байна.

Мөн дүүргийн 21 хороодыг “Өргөдөл, гомдлын дэд систем” ERP програмаар иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх, уламжлах ажлыг жигдрүүлэхэд анхаарч 14 хоног

тутам хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнд шийдвэрлэлтийн үзүүлэлтийн тайланг бэлтгэн танилцуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн дүүргийн Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг “Статистикийн мэдээлэл” гарын авлагад нийтлүүлж байна.

ГУРАВ. ЗАСАГ ДАРГА ИРГЭДЭД МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛСЭН ТУХАЙ

Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай журам”-ыг мөрдөн, ажиллаж байна.

Журамд заасны дагуу хороодын Хөгжлийн нийгмийн ажилтныг мөнгөн тусламж хүссэн иргэдийн гэрээр очиж судлуулан нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн 2021 оны 12 дугаар сарын 27-ны байдлаар нийт 92 иргэнд 33,100,000 /гучин гурван сая нэг зуун мянган төгрөг/ нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон байна.

Үүнд:

- А/114 дүгээр захирамжаар нийт 27 иргэнд 9,000,000 төгрөг
- А/186 дугаар захирамжаар нийт 6 иргэнд 2,700,000 төгрөг
- А/455 дугаар захирамжаар нийт 27 иргэнд 9,500,000 төгрөг
- А/558 дугаар захирамжаар нийт 12 иргэнд 5,300,000 төгрөг
- А/652 дугаар захирамжаар нийт 18 иргэнд 6,600,000 төгрөг
- 2 иргэний буцалтгүй тусламж хүссэн өргөдөлийг “Хорт хавдартай тэмцэх сан”-аар дамжуулан тус тус шийдвэрлэн, олгож ажилласан байна.

ДӨРӨВ. ЗАСАГ ДАРГЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

Дүүргийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/38 дугаар захирамжаар “Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу уулзалтыг долоо хоногийн мягмар гарагт шаардлагатай тохиолдолд пүрэв гарагт батлагдсан хуваарийн дагуу иргэдийг хүлээн авч уулзан санал, хүсэлтийг сонсон шийдвэрлэж, хариу өгч байна. Уулзалтаар иргэдээс тавьж буй санал, хүсэлтийг газар дээр шийдвэрлэж, хариу өгөх зорилгоор чиг үүргийн хамааралтай хэлтэс албадын удирдлагуудыг оролцуулж байна.

Корона вирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар А/108 тоот Нийслэлийн Засаг даргын захирамжийн 1.3-т заасны дагуу олон нийтийн арга хэмжээ буюу хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулахыг түр зогсоосон байсан тул 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс хойш 3 удаагийн уулзалт зохион байгуулж, 24 иргэнтэй уулзаж, гарсан санал, хүсэлтийг холбогдох хэлтэс, албадын даргад газар дээр нь өгсөн үүрэг чиглэлийн шийдвэрлэлтийг нэгтгэж биелэлтийн тайлан гаргаж ажилласан.



ТАВ. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

“Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган 2021 оны тайлант хугацаанд давхардсан тоогоор 180,360 иргэн үйлчлүүлсэн байна. “Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, короновирус цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд сэрэмжлүүлж, халдвар хамгааллын дэглэм сахиж ажиллалаа. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр өдөрт 400-500 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд Өргөдөл гомдол хүлээн авах, Эд хөрөнгийн бүртгэл, гэрчилгээ олгох, Гадаад паспорт хүлээн авах, олгох, Газар зохион байгуулалтын алба, Хуулийн этгээдийн бүртгэл, гэрчилгээ олгох, Хүнс, худалдаа үйлгээний хэлтэс, Иргэний бүртгэл, олголт, Нотариат, Кадастр, Канон/Зурагчин/ зэрэг 15 цонхоор 69 төрлийн үйлчилгээ хүргэдэг.

Үүнээс гадна иргэдэд зориулан ТҮЦ машин, улсын бүртгэлийн хураамж, газар зохион багуулалтын албаны хураамж, татвар, торгууль, шүүхийн тэмдэгтийн хураамж, вакцины бичиг, Ковидын шинжилгээний хариу гэх мэт үйлчилгээг хялбар, шуурхай шийдэх боломжтой ГЭРЭГЭ киоск автомат машин ажиллаж байна.

Нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар /давхардсан тоогоор/

| № | Үйлчилгээний төрөл | 2021 оны 12 дугаар сар/өссөн дүнгээр/ |
|---|------------------------------------|---------------------------------------|
| 1 | Газар зохион байгуулалтын алба | 30,960.00 |
| 2 | Эд хөрөнгийн эрхийн бүртгэл | 74,520.00 |
| 3 | Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс | 9,360.00 |

| | | |
|----------|---------------------------|------------|
| 4 | Хуулийн этгээдийн бүртгэл | 9,720.00 |
| 5 | Иргэний бүртгэл | 5,760.00 |
| 6 | Гадаад паспорт | 7,920.00 |
| 7 | Нотариат | 13,320.00 |
| 8 | Канон, түргэн зурагчин | 24,480.00 |
| 9 | Газрын кадастр | 4,320.00 |
| Нийт дүн | | 180,360.00 |

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.САРАНГУА

БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АЖИЛТАН

Г.ЭРДЭНЭСУГАР